## ГАРЧИГ

*НЭГ. 2025 ОНЫ УУЛЫН АЖЛЫН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА* ...... 3
*1.1. Төслийн ерөнхий мэдээлэл* ...... 3
*1.2. Уурхайн ашиглалтын систем, ажиллах горим, техник тоног төхөөрөмж* ...... 5
*ХОЁР. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ* ...... 9
*ГУРАВ. УУРХАЙН НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ* ...... 15
*ДӨРӨВ. БИОЛОГИЙН ОЛОН ЯНЗ БАЙДЛЫГ ДҮЙЦҮҮЛЭН ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ* ...... 16
*ТАВ. НҮҮЛГЭН ШИЛЖҮҮЛЭХ, НӨХӨН ОЛГОВОР ОЛГОХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ* ...... 18
*ЗУРГАА. ТҮҮХ, СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ* ...... 18
*ДОЛОО. ОСОЛ, ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ* ...... 19
*НАЙМ. ХОГ, ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ* ...... 20
*ЕС.ТУХАЙН ЖИЛИЙН ОРЧНЫ ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨРИЙН БИЕЛЭЛТ* ...... 25
*АРАВ. УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ* ...... 28
*АРВАН НЭГ. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТИЙГ НӨЛӨӨЛӨЛД ӨРТӨГЧ ОРШИН СУУГЧИД, ОРОЛЦОГЧ ТАЛУУДАД ТАЙЛАГНАХ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ* ...... 30
*ДҮГНЭЛТ* ...... 31

## ХҮСНЭГТИЙН ГАРЧИГ

*Хүснэгт 1. Төслийн товч танилцуулга* ...... 3
*Хүснэгт 2. MV-017195 тоот ашиглалтын тусгай зөвшөөрлийн солбицлын цэгүүд* ...... 3
*Хүснэгт 3. Уурхайн ажиллах горим* ...... 6
*Хүснэгт 4. Уурхайн уулын ажлын календарчилсан төлөвлөгөө* ...... 6
*Хүснэгт 5. Төслийн үндсэн тоног төхөөрөмжүүд* ...... 6
*Хүснэгт 6. 2025 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хүрээнд хийж гүйцэтгэсэн ажлын зардал* ...... 30

## ЗУРГИЙН ГАРЧИГ

*Зураг 1. Төслийн байршлын зураг* ..... 4
*Зураг 2. Бутлах үйлдвэрийн технологийн схем* ..... 7
*Зураг 3. Бутлах цехийн тоног төхөөрөмжийн холболтын схем* ..... 7
*Зураг 4. Уурхай орчимд тэмдэг тэмдэглэгээ байршуулсан байдал* ..... 10
*Зураг 5. Уурхайн талбайд мод тарьсан байдал* ..... 11
*Зураг 6. Ус ашиглуулах дүгнэлт* ..... 12
*Зураг 7. Ус ашиглуулах дүгнэлт* ..... 13
*Зураг 8. Ус ашиглуулах дүгнэлт* ..... 14
*Зураг 9. Ус ашигласны төлбөрийн баримт* ..... 15
*Зураг 10. Дүйцүүлэн хамгаалах ажлын тайлан* ..... 16
*Зураг 11. Дүйцүүлэн хамгаалах ажлын тайлан* ..... 17
*Зураг 12. Уурхайн талбайд байрлуулсан галын булан* ..... 19
*Зураг 13. Хог хаягдлын цэг* ..... 20
*Зураг 14. Аюултай хог хаягдлын цэг* ..... 21
*Зураг 15. Хог хаягдал ачиж тээвэрлэх гэрээ* ..... 22
*Зураг 16. Хог хаягдал ачиж тээвэрлэх гэрээ* ..... 23
*Зураг 17. Хог хаягдлын төлбөр төлсөн баримт* ..... 24
*Зураг 18. Хөрсний шинжилгээний хариу* ..... 25
*Зураг 19. Усны шинжилгээний хариу* ..... 26
*Зураг 20. Агаарын чанар, дуу чимээний шинжилгээний хариу* ..... 27
*Зураг 21. Ажилчдын хувцас* ..... 28
*Зураг 22. Хөдөлмөр хамгааллын хувцас худалдан авсан баримт* ..... 28
*Зураг 23. Хөдөлмөр хамгааллын хувцас худалдан авсан баримт* ..... 29

# НЭГ. 2025 ОНЫ УУЛЫН АЖЛЫН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

## *1.1.Төслийн ерөнхий мэдээлэл*

*Хүснэгт 1. Төслийн товч танилцуулга*

| № | Үндсэн үзүүлэлтүүд | Тайлбар |
|---|---|---|
| 1 | Төсөл хэрэгжүүлэгч байгууллага | "БИ СИ ЭМ ЭМ" ХХК |
| 2 | Төсөл хэрэгжүүлэгчийн хаяг | Хан-Уул дүүрэг, 13-р хороо, өөрийн байр. |
| 3 | Төслийн нэр | "Үнэсгэний хөндий-1" нэртэй барилгын чулууны ордыг ил уурхайн аргаар ашиглах |
| 4 | Хүчинтэй хууль эрх зүйн баримт бичгийн жагсаалт | 1. Аж ахуй улсын бүртгэлийн гэрчилгээ: Улсын бүртгэлийн дугаар: 9019061095 Улсын регистрийн дугаар: 5315425 2. Ашигт малтмал ашиглах тусгай зөвшөөрөл: Дугаар: MV-017195 |
| 5 | Ашигт малтмал ашиглах тусгай зөвшөөрлийн талбайн солбицол | Газар зүйн солбицол: ТЗ: MV-00007 Талбай: 40.25 га 106° 34' 50.00" - 47° 49' 23.00" 106° 35' 09.00" - 47° 49' 23.00" 106° 35' 09.00" - 47° 49' 50.00" 106° 34' 50.00" - 47° 49' 50.00" |
| 6 | Ордын геологийн бодит (B) нөөц | Барилгын чулуу: 3 349.33 мян.$м^3$ |
| 7 | Ордын үйлдвэрлэлийн нөөц | Барилгын чулуу: 2 882.06 мян.$м^3$ |
| 8 | Жилийн хүчин чадал | Барилгын чулуу: 250.0 мян.$м^3$ |
| 9 | Ордын ашиглалтын хугацаа | 12 жил |
| **10** | **Анхны хөрөнгө оруулалт** | **20.98 сая.төг** |

***Төслийн байршил:*** MV-017195 тоот ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй "Үнэсгэний хөндий-1" барилгын чулууны ордын талбай нь Улаанбаатар хотын Хан-Уул дүүргийн нутагт Улаанбаатар хотоос БУ 30 км, Шувуун фабрикаас ЗХ 8 км-т Сонгинохайрхан уулын баруун урд үзүүрийн намхан толгодлог хэсэгт байрлана.

Уг орд нь MV-017195 тоот ашиглалтын тусгай зөвшөөрөл бүхий талбайтай бөгөөд тусгай зөвшөөрлийн булангийн цэгүүдийн солбицлуудыг дараах хэсэгт харууллаа.

*Хүснэгт 2. MV-017195 тоот ашиглалтын тусгай зөвшөөрлийн солбицлын цэгүүд*

| Д/д | Хойд өргөрөг | Зүүн уртраг |
|---|---|---|
| 1 | 47° 49' 23.0" | 106° 34' 50.0" |
| 2 | 47° 49' 23.0" | 106° 35' 09.0" |
| 3 | 47° 49' 50.0" | 106° 35' 09.0" |
| 4 | 47° 49' 50.0" | 106° 34' 50.0" |




*Зураг 1. Төслийн байршлын зураг*

## 1.2. Уурхайн ашиглалтын систем, ажиллах горим, техник тоног төхөөрөмж

### 1.2.1. Ашиглалтын систем, ажиллах горим

***Үйлдвэрлэл явуулах үндсэн шийдэл***

Ордын нийт нөөцийг 3349.33 мян.$м^3$-ээр тооцсон ба үүнээс үйлдвэрлэлийн нөөц нь 2882.06 мян.$м^3$ байна. Техник эдийн засгийн үндэслэлийг хийж гүйцэтгэхдээ захиалагч талын саналын дагуу олборлолтод 3.5 $м^3$ утгуурын багтаамжтай Komatsu PC600 маркийн экскаватор, HOWO 20 тн автосамосвалын хослол ашиглаж, мөн LiuGong 50 маркийн утгуурт ашиглан жилд 250.0 мян.$м^3$ дайргыг ил аргаар олборлохоор төслийг боловсрууллаа.

Уурхайн өдөр тутмын үйл ажиллагааг шуурхай удирдлагаар хангах, техник тоног төхөөрөмжийг засварлах, тэдгээрийг хадгалах, үйлчилгээ материал хангамжийг газар дээр нь зохион байгуулах үүднээс уурхайн дэргэд захиргаа аж ахуйн байгууламж барьж байгуулна.
Уурхайн бүрэлдэхүүнд дараахь объектууд орно. Үүнд:

*Үйлдвэрийн объектууд:*

- ✓ Дайргыг ангилан ялгах төхөөрөмж
- ✓ Сэлбэг хэрэгслийн агуулах
- ✓ Дизель станц,
- ✓ Бусад байгууламжууд г.м

*Туслах объектууд:*

- ✓ Захиргаа аж ахуйн байр, хоолны газар /нарядны өрөө/
- ✓ Ажилчдын байр
- ✓ Халуун усны байр
- ✓ Машин тоног төхөөрөмжийн түр гарааж /сарай/, засварын газар
- ✓ Харуул хамгаалалтын байр
- ✓ Бие засах газар
- ✓ Хамгаалалтын хашаа г.м

Уурхайн түр тосгон нь тусгай сонгосон талбайд байрлах ба объектууд 24 цагийн турш харуул хамгаалалтанд байна. Ажилчдын байр, халуун усны байр, захиргаа аж ахуйн байрыг тохижуулсан контейнер ашиглан бүрдүүлнэ.

### 1.2.2. Уурхайн ажиллах горим.

Уурхайн олборлолт хөрс хуулалтын үйл ажиллагаа нь 05 сарын 01-ны өдрөөс 10 сарыг дуустал дулааны улиралд явагдах бөгөөд Монгол улсын хууль тогтоомжид заасны дагуу олон нийтээр амрах баяр ёслолын хоногууд, цаг агаарын саатал, засвар үйлчилгээ зэрэг хүчин зүйлийг тооцсон. Уурхай нь хөрс хуулалт, уурхайгаас дайргыг олборлох, зөөвөрлөх, ангилан ялгах зэрэг үндсэн үйл ажиллагаа нь өдөрт 2 ээлжээр, ээлжинд 8 цагаар ажиллана. Уурхай нь**:**

**УУРХАЙ НЬ:**

**ХӨРС ХУУЛАЛТ ►ӨРӨМДЛӨГ ТЭСЭЛГЭЭ►ДАЙРГА ОЛБОРЛОЛТ ►ТЭЭВЭРЛЭЛТ ► ДАЙРГЫГ БУТЛАХ, АНГИЛАН ЯЛГАХ, ► БЭЛЭН БҮТЭЭГДЭХҮҮНИЙГ ХЭРЭГЛЭГЧДЭД АЧИЖ НИЙЛҮҮЛЭХ** гэсэн технологийн үндсэн горимын дагуу ажиллана.

*Хүснэгт 3. Уурхайн ажиллах горим*

| № | Үзүүлэлт | Хэмжих нэгж | Хэмжээ |
|---|---|---|---|
| 1 | Хуанлийн хоног | хоног | 180 |
| 2 | Баяр ёслол | хоног | 6 |
| 3 | Бэлтгэл ажлын хоног | хоног | 5 |
| 4 | Уурхайн жилд цэвэр ажиллах хоног | хоног | 169 |
| 5 | Хоногт ажиллах ээлжийн үргэлжлэх хугацаа | цаг | 16 |
| 6 | Ээлжийн тоо | ш | 2 |
| 7 | Нийт ажиллах цаг | цаг | 2704 |

Энд ажлын үргэлжлэх хугацаанд тохиолдох албан ёсны амралт, баяр ёслолын өдрүүдийг тооцон хөрс хуулалтын ажил, олборлолт, ангилан ялгах төхөөрөмжийн ажиллах хугацаа 169 өдөр гэж тооцоолсон болно.

### 1.2.3. Уурхайн хүчин чадал, календарь төлөвлөгөө

"Үнэсгэний хөндий-1" барилгын чулууны ордын B-1 блокоос эхэлж олборлохоор төлөвлөв. Уулын ажлыг явуулахдаа хөрс хуулалтын явцад хуулсан хөрсийг зам талбайн ажилд хэрэглэн процессуудын хоорондын уялдаа холбоог уян хатан байлгах боломжийг бий болгож байгаа юм. Ордын хөрсний зузаан 0.5 м, барилгын чулууны зузаан 31.5 м байгаа тул уурхайн доголын өндөр дунджаар 5 м орчим байхаар байна. Уурхайн хажуугийн тогтворжилтыг хангахын тулд уурхайн хажуугийн өнцгийг 65-70 градусаас ихгүй налуутай байгуулна.

*Хүснэгт 4. Уурхайн уулын ажлын календарчилсан төлөвлөгөө*

| Ашиглалтын жил | Уулын цул | | Нийт хөрс | | Үндсэн хөрс | Шимт хөрс | Үйлдвэрлэлийн нөөц | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| Хэмжих нэгж | **мян.м$^3$** | **мян.тн** | **мян.м$^3$** | **мян.тн** | **мян.м$^3$** | **мян.м$^3$** | **мян.м$^3$** | **мян.тн** |
| **1-р жил** | 314.69 | 805.24 | 64.69 | 155.24 | 63.76 | 0.93 | 250.00 | 650.00 |
| **2-р жил** | 314.69 | 805.24 | 64.69 | 155.24 | 63.76 | 0.93 | 250.00 | 650.00 |
| **3-р жил** | 314.69 | 805.24 | 64.69 | 155.24 | 63.76 | 0.93 | 250.00 | 650.00 |
| **4-р жил** | 314.69 | 805.24 | 64.69 | 155.24 | 63.76 | 0.93 | 250.00 | 650.00 |
| **5-р жил** | 314.69 | 805.24 | 64.69 | 155.24 | 63.76 | 0.93 | 250.00 | 650.00 |
| **6-12-р жил** | 2084.85 | 5330.06 | 452.80 | 1086.71 | 446.29 | 6.51 | 1632.06 | 4243.35 |
| Нийт | **3658.28** | **9356.29** | **776.22** | **1862.93** | **765.06** | **11.16** | **2882.06** | **7493.35** |

### 1.2.4. Төслийн тоног төхөөрөмж

Олборлолтонд 3.5 м$^3$ утгуурын багтаамжтай Komatsu PC600 маркийн экскаватор, HOWO 20 тн автосамосвалын хослол ашиглаж, мөн LiuGong 50 маркийн утгуурт ашиглан жилд 250.0 мян.м$^3$ дайргыг ил аргаар олборлохоор төслийг боловсруулллаа.

*Хүснэгт 5. Төслийн үндсэн тоног төхөөрөмжүүд*

| № | Тоног төхөөрөмжүүд | Марк | Хэмжих нэгж | Тоо |
|---|---|---|---|---|
| **1** | Экскаватор | Komatsu | ш | 2 |
| **2** | Автосамосвал | HOWO | ш | 4 |
| **3** | Утгуурт ачигч | LIUGONG50 | ш | 1 |
| **4** | Бульдозер /түрээс/ | SD-16 | ш | 1 |
| **5.** | Өрмийн машин | ATLAS COPCO AIR ROCK D65 | ш | 1 |
| | Нийт | | | 9 |

***Ангилан ялгах тоног төхөөрөмжийн технологийн схем***

Тус төсөлд тусгагдсан дайрга бутлуурын иж бүрэн тоног төхөөрөмж нь хацарт болон конусан бутлуур, туузан дамжуурга, доргиурт болон ангилагч шигшүүр, бункер зэргээс бүрдэнэ.




***Зураг 2. Бутлах үйлдвэрийн технологийн схем***




***Зураг 3. Бутлах цехийн тоног төхөөрөмжийн холболтын схем***

***Тухайн жилийн уулын ажлын төлөвлөгөөний биелэлт***

2025 онд уулын ажлын календарчилсан төлөвлөгөөний дагуу 250.0 мян.$м^3$ барилгын чулуу олборлон борлуулахаар төлөвлөсөн боловч 2025 оны 10-р сарын байдлаар 100.0 мян.$м^3$ барилгын чулуу олборлож, үйлдвэрт нийлүүлсэн байна.

# ХОЁР. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

| № | Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд | Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ | Төлөвлөлтийг хэрэгжүүлсэн байдал |
|---|---|---|---|
| 1 | Уурхай орчимд тоосжилт үүсэх | Уурхайн ам орчимд болон тээврийн гол замыг чийгшүүлэх, услах, дагтаршуулах | Уурхайн карьер болон тээврийн гол замыг чийгшүүлэх, услах ажлыг тогтмол хийж гүйцэтгэсэн. |
| 2 | | Жил бүрийн орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн дагуу агаар, орчин дахь тоосны хэмжээг тодорхойлж байх | ОХШХ-ийн дагуу хяналт шинжилгээг хийлгэсэн. |
| 3 | Ашиглаж буй усны чанар муудах, хүрэлцээ бага байх | Ус ашиглах дүгнэлтийг жил бүрийн эхэнд гаргуулах | Ус ашиглах дүгнэлт гаргуулж, гэрээ байгуулан усны төлбөрийг төлсөн. |
| 4 | | Ус ашигласны төлбөрийг цаг тухайд нь тогтмол хугацаанд төлөх | |
| 5 | | Унд, ахуйн хэрэглээний усанд тогтмол шинжилгээ хийлгэж байх | Усны шинжилгээ хийлгэсэн. |
| 6 | Төслийн үйл ажиллагааны явцад ихээхэн талбайн хөрс овоолго, уурхайн тосгон, бусад байгууламжуудын дор дарагдаж, элэгдэл, эвдрэлд өртөнө. | Овоолго болон бусад байгууламжуудыг байгуулахын өмнө өнгөн хөрсийг хуулан авах, | Шимт хөрсний овоолго үүсгэн хадгалсан. |
| | | Хуулж авсан өнгөн хөрсийг тусгайлан овоолго байгуулан хадгалах | |
| | | Шимт хөрсний үржил шимийг алдагдахаас хамгаалж, өндөрлөж овоолго үүсгэх болон дагтаршуулахгүй байх | |
| 7 | Уурхайн замын ачааллаас хөрс элэгдэж, эвдрэлд орох | Хүнд машин механизм явах замыг засаж сайжруулан, байгалийн хөрс бүхий замаар тээвэрлэлт аль болох бага хийх | Уурхайн карьер болон тээврийн гол замыг чийгшүүлэх, услах ажлыг тогтмол хийж гүйцэтгэсэн. |
| 8 | Элсэн чулуу олборлосоноор газрын хэвлийд хоосон орон зай шинээр үүсгэнэ. | Уурхайн малталтууд болон олборлосон орон зайд бэхэлгээ, хамгаалалтын цул зэргийг үлдээж нуралт үүсэхээс сэргийлнэ | Уурхай орчимд тэмдэг тэмдэглэгээ байршуулсан. |
| 9 | Уурхайгаас олборлосон элсэн чулууг бутлах, ангилах зэрэг ажлын үед ургамал устах, дарагдах, талхлагдах зэргээр хамгийн их нөлөөлөлд өртөнө. | Нөхөн сэргээлтэнд ашиглах хөрсний шимт хэсгийн овоолгыг стандартын дагуу тусгайлан овоолж, салхинд хийсэхээс хамгаалах. | Шимт хөрсний овоолго үүсгэн хадгалсан. |
| 10 | Амьтны аймагт хохирол учруулах, тоо толгой хорогдох, идэш тэжээлийн хомсдол үүсэх | Мал амьтан өнгөрч гардаг хэсгүүдэд тэмдэг, тэмдэглэгээ байрлуулах, Авто машины хурдыг тогтоосон хязгаарт байлгах | Уурхай орчимд тэмдэг тэмдэглэгээ байршуулсан. |



*Зураг 4. Уурхай орчимд тэмдэг тэмдэглэгээ байршуулсан байдал*





***Зураг 5. Уурхайн талбайд мод тарьсан байдал***

"Тэрбум мод" үндэсний хөдөлгөөний хүрээнд уурхайн талбайд 50 ш мод суулгасан.

Нийслэлийн байгаль орчны газар

## УС АШИГЛУУЛАХ ДҮГНЭЛТ

2025 оны 10 -р сарын 27 -ны өдөр

Дугаар E-2508-000149

**1. Аж ахуйн нэгж байгууллага, захирлын нэр, утас, факс, улсын бүртгэлийн болон регистрийн дугаар**

| | |
|---|---|
| Оноосон нэр: | Би Си Эм Эм ХХК |
| Улсын бүртгэлийн дугаар: | |
| Регистрийн дугаар: | 5315425 |
| Захирал: | Ганбаатар |
| Холбоо барих дугаар: | 94106009 |
| Факс : | |
| И-мэйл хаяг : | |

**2.Төслийн нэр байршил**

| | |
|---|---|
| Төслийн нэр: | "Үнэсгэний хөндий-1" нэртэй барилгын чулууны ордыг ашиглах |
| Байршил: | Улаанбаатар, Хан-Уул, 13-р хороо |
| Харьяалагдах сав газар: | Туул голын сав газар |
| Хамаарах салбар: | Уул уурхай |
| Төслийн дэлгэрэнгүй: | Уурхай нь жилд 250.0 мян.м3 барилгын чулуу олборлох ба жилд 169 хоног, нэг ээлжээр 84 хүн ажиллана. |

**3. Төсөл хэрэгжүүлэгчийн нэр**

Би Си Эм Эм

**4. Ажиллах горим, хүчин чадал**

| Үргэлжлэх хугацаа | Ажиллах горим | Жилд ажиллах хоног | Хоногт ажиллах ажилчдын тоо | Хоногт ажиллах цаг |
|---|---|---|---|---|
| 5 | 1 ээлжээр | 169 | 84 | 8 |

**5. Үйлдвэрлэх, боловсруулах бүтээгдэхүүн, ажил, үйлчилгээний хэмжээ**

| Ажлын нэр | Тоо хэмжээ | Хэмжих нэгж | Тайлбар |
|---|---|---|---|
| Ашиг олох зориулалтаар ахуйн үйлдвэрлэл, үйлчилгээнд ашиглах усны хэмжээ | 84.0 | хоногт 1 хүн | Төслийн байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний нэмэлт тодотгол тайлангийн мэдээлэлд үндэслэв. |
| Зам талбайн тоосжилт дарахад ашиглах усны хэмжээ | 1900.0 | м2 | Төслийн байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний нэмэлт тодотгол тайлан, ТЭЗҮ мэдээлэлд |

***Зураг 6. Ус ашиглуулах дүгнэлт***

| Ажлын нэр | Тоо хэмжээ | Хэмжих нэгж | Тайлбар |
|---|---|---|---|
| | | | үндэслэв. |

### 6. Усны эх үүсвэр, нөөц, хоногт ашиглах хэмжээ

| Эх үүсвэр | Зориулалт | Усны нөөц (л) | Усны нөөц (м3) | Тайлбар |
|---|---|---|---|---|
| Гүний худаг | Унд ахуй | 1.0 | 86.4 | Уурхайд технологийн ус ашиглахгүй бөгөөд унд ахуйн усыг өөрийн эзэмшлийн гүний худгаас хангадаг. |

### 7.Байгаль орчны нөлөөллийн үнэлгээ, нөхцөл

Байгаль орчны нөлөөллийн үнэлгээ боловсруулсан ААНБ : Саут воли ХХК

Холбоо барих : 80112635

Нэмэлт мэдээлэл:

### 8. Усны барилга байгууламжууд

| Барилга байгууламж | Хүчин чадал (м3) | Хэмжээ хийц |
|---|---|---|

### 9. Дамжуулах байгууламж

| Хаанаас (эхлэх цэг) | Хаана хүртэл (төгсгөлийн цэг) | Шугамын голч, мм | Дамжуулах шугамын урт, м |
|---|---|---|---|

### 10. Онцгой нөхцөл

Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний тайланд тусгагдсан төслөөс байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээг менежментийн төлөвлөгөөнд тусган хэрэгжилтийг бүрэн хангуулан ажиллах шаардлагатай.

### 11. Усны зарцуулалт

| Ажлын нэр | Тоо Хэмжээ | Хэмжих нэгж | Усны хэрэглээ, м3 (Норм) | Гүйцэтгэх давтамж | Хэмжих нэгж | Нийт ашиглах усны хэмжээ, м3 | Хөнгөлөх усны хэмжээ м3 | Төлбөр тооцох усны хэмжээ м3 |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| Ашиг олох зориулалтаар ахуйн үйлдвэрлэл, үйлчилгээнд ашиглах усны хэмжээ | 84 | хоногт 1 хүн | 0.08 | 169.0 | Хоног | 1,135.68 | 0.00 | 1,135.68 |
| Зам талбайн тоосжилт дарахад ашиглах усны хэмжээ | 1900 | м2 | 0.002 | 24.0 | Удаа | 91.20 | 0.00 | 91.20 |
| Нийт | | | | | | 1,226.88 | 0.00 | 1,226.88 |

### 12. Урьдчилсан байдлаар тооцсон усны нөөц ашигласны төлбөрийн хэмжээ

*Зураг 7. Ус ашиглуулах дүгнэлт*

| Ажлын нэр | Төлбөр тооцох усны хэмжээ, м3 | Усны ангилал | Хөнгөлөх хувь хэмжээ, % | 1 м3 усны үнэ | Усны нөөц ашигласны төлбөр, ₮ | Төлбөрөөс хөнгөлсөн дүн, ₮ | Төлбөл зохих дүн, ₮ |
|---|---|---|---|---|---|---|---|
| Ашиг олох зориулалтаар ахуйн үйлдвэрлэл, үйлчилгээнд ашиглах усны хэмжээ | 1135.68 | Газрын доорх ус | 0.0 | 99.12 | 112,568.60 | 0.0 | 112,568.60 |
| Зам талбайн тоосжилт дарахад ашиглах усны хэмжээ | 91.20 | Газрын доорх ус | 0.0 | 99.12 | 9,039.74 | 0.0 | 9,039.74 |
| Нийт | 1,226.88 | | | | 121,608.35 | | 121,608.35 |

13. Үйлдвэрлэл, үйлчилгээнд усны нөөцийг хэмнэх эргүүлж ашиглах даалгавар

- Үйлчилгээнээс гарч буй бохир усыг стандартын шаардлагад нийцтэл цэвэрлэх бага оврын цэвэрлэх байгууламжтай байх.
- Усны тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2. дахь хэсэгт заасны дагуу хаягдал усны дүгнэлтийг Туул голын сав газрын захиргаанаас авах.
- UCS 0701B:2022 Бие даасан усан хангамж, худаг, ус агуулах саванд тавих ерөнхий шаардлага хотын стандартыг хэрэгжүүлэх.

14. Тавигдах шаардлага, цаашид авах арга хэмжээ, зөвлөгөө

- Усны тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.6, 28.8, 28.11, 29.1-д заасны дагуу Хан-Уул дүүргийн Засаг даргын Тамгын газартай 2025 оны ус ашиглах гэрээ байгуулах.
- Усны нөөц ашигласны төлбөрийг 2025 оны 12-р сарын 25-ны дотор Хан-Уул дүүргийн Татварын хэлтсийн дансанд төлөх.
- Усны нөөц ашигласны төлбөрийг хугацаанд нь төлөөгүй тохиолдолд Усны тухай хуулийн 33.1.10-т заасны дагуу хариуцлага тооцохыг анхаарах.
- Тоолуурын заалтын баталгаа алдагдсан, шугам хоолойгоос салгасан тохиолдолд усны нөөц ашигласны төлбөрийг Байгаль орчин, ногоон хөгжил, аялал жуулчлалын сайдын 2015 оны А/301 дүгээр тушаалаар батлагдсан "Нэгж бүтээгдэхүүн үйлдвэрлэх, ажил гүйцэтгэх, үйлчилгээ үзүүлэхэд зарцуулах усны норм"-оор тооцож онигдуулахыг анхаарах.
- Гэрээнд заасныаас илүү ашигласан усанд Засгийн газрын 2018 оны 391 дүгээр тогтоолоор батлагдсан "Зөвшөөрсөн хэмжээнээс илүү ашигласан усны төлбөр тооцох журам"-ын дагуу шатлан өсгөх хэлбэрээр тооцохыг анхаарах.
- Зөвлөмжийн хэрэгжилтийг тухайн жилийн ус ашиглалтын тайланд тусган 2026 онд ус ашиглуулах дүгнэлт гаргуулах хүсэлтийн хамт ирүүлэх.

Боловсруулсан:

БАТАЛГААЖЛАА

Байгууллагын нэр: Нийслэлийн байгаль орчны газар
Газар хэлтэс: Захиргаа
Албан тушаал: Даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч
Овог нэр: Насанбат Мөнхбаяр
Зурсан огноо: 2025.10.27 15:49:45

*Зураг 8. Ус ашиглуулах дүгнэлт*



ХААН БАНК

Огноо/Date: 2025-10-03 14:09:09

Шилжүүлгийн мэдээлэл/Transaction information

Журналын /Journal No: 23304966

Системийн огноо/System Date: 2025-10-03 14:08:57

| | | | | |
|---|---|---|---|---|
| Дт | IBAN/Дансны/Картын дугаар IBAN/Account/Card number: 5070017051 | Нэр/Name: НЭРГҮЙ ГАНДОЛГОР | Дүн/Amount: 375,240.00 MNT | Ханш/Rate: 1.00 |
| Кт | Банкны дугаар/Branch No: 050000; IBAN/Дансны/Картын дугаар IBAN/Account/Card Number: 5176120446 | Банкны нэр/Bank Name: ХААН БАНК; Нэр/Name: ТАТВАРЫН ЕРӨНХИЙ ГАЗАР | 375,240.00 MNT | 1.00 |

Гүйлгээний утга/Transaction description:
2251000457124; ШГ73012066; 94102509

*Зураг 9. Ус ашигласны төлбөрийн баримт*

## ГУРАВ. УУРХАЙН НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

2025 оны уулын ажлын төлөвлөгөөнд техникийн болон биологийн нөхөн сэргээлтийн ажил төлөвлөгдөөгүй болно.

# ДӨРӨВ. БИОЛОГИЙН ОЛОН ЯНЗ БАЙДЛЫГ ДҮЙЦҮҮЛЭН ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөөний хүрээнд НБОГ-тай хамтран "Гавьжийн шанд"-ын булгийн эхийг хамгаалан тохижуулах ажлыг хийж гүйцэтгэсэн болно.



ДҮЙЦҮҮЛЭН ХАМГААЛЛААР ГАВЬЖИЙН ШАНДЫН БУЛГИЙН ЭХИЙГ ХАМГААЛАН ТОХИЖУУЛСАН АЖЛЫН ТАЙЛАН

2025.10.05 Улаанбаатар хот

Нийслэлийн Хан-Уул дүүргийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж буй түгээмэл тархацтай ашигт малтмалын ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй "Боржин зам" ХХК, "Өгөөмөр гоулд" ХХК, "Суурь хана" ХХК, "Просперити ресоурсес" ХХК, "Ядам од" ХХК, "Кастл петро майнинг" ХХК, "Өвөр харзат" ХХК, "Уянхайрхан" ХХК, "Би Си Эм Эм" ХХК, "Очирням" ХХК зэрэг аж ахуйн нэгжүүдийн 2025 оны уулын ажлын төлөвлөгөө, байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд тусгагдсан дүйцүүлэн хамгааллын хөрөнгөөр Нийслэлийн Хан-Уул дүүргийн 14 дүгээр хорооны нутаг дэвсгэрт байрлах Гавьжийн шанд нэртэй булгийн эхийг хашиж хамгаалах ажлыг 2025 оны 9 дүгээр сарын 26-30-ны өдрүүдэд хийж гүйцэтгэн тохижуулав.

Нийслэлийн Байгаль орчны газрын захиалгын дагуу булаг шандны эхийг хашиж хамгаалах аргачлал ажлын даалгавраар тохижуулах ажлыг хийж гүйцэтгэв.

Гавьжийн шанд булаг нь Нийслэлийн Хан-Уул дүүргийн 14 дүгээр хорооны нутаг дэвсгэр Өлзийтхайрхан уулын өвөр хөндийд байрласан хуурай цайрд шуурган урсадаг булаг юм. Нутгийн 10 орчим айл өрхийн 30 орчим хүн, мөн 200 орчим адуу ,үхэр нийлсэн бод мал ундаалан усан хангамжийг хангадаг байна. Нутгийн иргэдийн яриагаар бол дотор эрхтэн сайн талын удвистай талаар дурдсан болно. Булгийн эх хэсэгт адуу, үхэр ихээр ирж ундаалах эх хэсэгт олноор зогсож баас шээсээр булгийн эхийг бохирдуулснаар булгийн ундарга багасаж бохирдсоноор талхагдаж ширгэх эрсдэлтэй байлаа. Эхийг хашиж хамгаалагдснаар булгийн ундарга сайжирч урсац нэмэгдэж иргэд хүн амын усан хангамж сайжрах сайн талтай байна.

Булгийн эхийн тэжээгдлийн мужийг тойруулан 28*32 метр харьцаатай хашааг 4 эгнээ төмөр татаж 3 метр зайтай шон дээр бэхлэн дунд тулаас бэхэлгээг 1,5 метр тутам нэмэлтээр хийж бэхлэсэн. Нутгийн иргэдийг орж ус авахаар цоожтой хаалга, мэдээллийн самбар зэргийг хийж тавьсан. Нутгийн иргэн Гантулга хариуцуулан хүлээлгэж өгч ээзэнжүүлсэн. Булгийн эх урсацын дагуу 200 метр газрын хог хаягдлыг цэвэрлэж 300 кг хогийг төвлөрсөн хогийн цэгт хүргэсэн.

Ажлын зургийг хавсралтаар гаргав.

Тайланг бичсэн:
"ЖАВАРТАЙ ӨВЛИЙН ЖАРГАЛ" ХХК-ИЙН
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ Д.БОЛОРТУЯА

*Зураг 10. Дүйцүүлэн хамгаалах ажлын тайлан*



**ДҮЙЦҮҮЛЭН ХАМГААЛЛААР ТОХИЖУУЛСАН БУЛГИЙН ЭХИЙГ ХАШИЖ ХАМГААЛСАН АЖЛЫН ГҮЙЦЭТГЭЛИЙГ ХҮЛЭЭН АВСАН АКТ**

2025 оны 10 дугаар сарын 07-ны өдөр №03/02. Улаанбаатар хот

Нийслэлийн Хан-Уул дүүргийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж буй түгээмэл тархацтай ашигт малтмалын ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй "Боржин зам" ХХК, "Өгөөмөр гоулд" ХХК, "Суурь хана" ХХК, "Просперити ресоурсес" ХХК, "Ядам од" ХХК, "Кастл петро майнинг" ХХК, "Өвөр харзат" ХХК, "Уянхайрхан" ХХК, "Би Си Эм Эм" ХХК, "Очирням" ХХК зэрэг аж ахуйн нэгжүүдийн 2025 оны уулын ажлын төлөвлөгөө, байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд тусгагдсан дүйцүүлэн хамгааллын хөрөнгөөр "Жавартай өвлийн жаргал" ХХК нь Нийслэлийн Хан-Уул дүүргийн 14 дүгээр хорооны нутаг дэвсгэрт байрлах Гавьжийн шанд нэртэй булгийн эхийг хашиж хамгаалах ажлыг 2025 оны 9 дүгээр сарын 25-30-ны өдрүүдэд хийж гүйцэтгэн тохижуулсан байна.

Гүйцэтгэгч тал нь Хан-Уул дүүргийн 14 дүгээр хорооны Гавьжийн шанд нэртэй булгийн эхийг хашиж хамгаалах ажлыг захиалагчийн ажлын даалгаварт тусгагдсаны дагуу хийж гүйцэтгэсэн байна.

Ажлын хэсгийн гишүүд "Булгийн эхийг хашиж хамгаалах" батлагдсан аргачлалын дагуу гүйцэтгэлийг захиалагчийн гаргасан ажлын даалгаварт нийцүүлэн гүйцэтгэсэн тул хүлээж авах боломжтой гэж шийдвэрлэв.

Хүлээн авсан:

Ажлын хэсгийн ахлагч: Ж.Батзолбоо — НБОГ-ын ХБОАХХ-ийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч

Гишүүд: Ч.Дамбасүрэн — НБОГ-ын НБАХХ-ийн Усны асуудал хариуцсан ахлах мэргэжилтэн

Д.Бат-Эрдэнэ — ХУД-ийн 14 дүгээр хорооны Засаг дарга

Ц.Саруулбаяр — Орон нутаг хариуцсан байгаль хамгаалагч

Нарийн бичиг: С.Сүхцоож — НБОГ-ын ХБОАХХ-ийн мэргэжилтэн

Хүлээлгэн өгсөн: Д.Болортуяа ("Жавартай өвлийн жаргал" ХХК-ийн гүйцэтгэх захирал)

*Зураг 11. Дүйцүүлэн хамгаалах ажлын тайлан*

## ТАВ. НҮҮЛГЭН ШИЛЖҮҮЛЭХ, НӨХӨН ОЛГОВОР ОЛГОХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

2025 онд нүүлгэн шилжүүлэх нөхөн олговор олгох арга хэмжээ төлөвлөгдөөгүй.

## ЗУРГАА. ТҮҮХ, СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

“Би Си Эм Эм” ХХК-ны тусгай зөвшөөрлийн талбайд палеонтологийн олдворын ул мөр ажиглагдаагүй байна. Түүнчлэн археологийн дурсгал илрээгүй байна.

# ДОЛОО. ОСОЛ, ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

Осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөөний хүрээнд уурхайд галын булан байрлуулсан бөгөөд өрөмдлөг тэсэлгээний ажлыг мэргэжлийн гэрээт байгууллагаар гүйцэтгүүлж, тэсрэх материалын сав баглаа боодлыг сервис компанид хүлээлгэн өгч аюул осолгүй ажилласан болно.

Түүнчлэн уурхайн талбайд галын булан байгуулсан.




*Зураг 12. Уурхайн талбайд байрлуулсан галын булан*

## НАЙМ. ХОГ, ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

Хог хаягдлын менежментийн төлөвлөгөөний хүрээнд хог хаягдлыг түр хадгалах цэгийг ангилан ялгах боломжтой байдлаар тохижуулсан бөгөөд "Хог хаягдал ачиж, тээвэрлэх гэрээ"-г "Хан-Уул дүүргийн тохижилт үйлчилгээний төв" ОНӨААТҮГ-тай байгуулан хуваарийн дагуу тогтмол тээвэрлүүлсэн болно.




*Зураг 13. Хог хаягдлын цэг*




*Зураг 14. Аюултай хог хаягдлын цэг*



БАТЛАВ
ХАН-УУЛ ДҮҮРГИЙН 13 ДУГААР ХОРООНЫ ЗАСАГ ДАРГА А.ЖАРГАЛТУЯА

БАТЛАВ
ХАН-УУЛ ДҮҮРГИЙН "ТҮТ" ОНӨААТҮГ-ЫН ЗАХИРАЛ В.МӨНХ-ЭРДЭНЭ

БАТЛАВ
"БИ СИ ЭМ ЭМ" ХХК-НЫ ЗАХИРАЛ В.ГАНБААТАР

**ХОГ ХАЯГДАЛ ЦУГЛУУЛАХ, ТЭЭВЭРЛЭХ ГЭРЭЭ**

2025 оны 05 сарын 06 өдөр | № 13/24 | Улаанбаатар хот

Нэг. Ерөнхий зүйл

1.1 Нэг талаас Хан-Уул дүүргийн 20 дугаар хороо, 5673461 тоот регистрийн дугаартай Хан-Уул дүүргийн "Тохижилт үйлчилгээний төв" ОНӨААТҮГ /цаашид Гүйцэтгэгч гэх/, нөгөө талаас 5315425 тоот регистрийн дугаартай, Хан-Уул дүүргийн 13 дугаар хорооны нутаг дэвсгэрт байрлах ашигт малтмал ашиглалтын чиглэлээр үйл ажиллагаа эрхэлдэг Би Си Эм Эм ХХК /цаашид захиалагч гэх / нар доорхи нөхцөлөөр харилцан тохиролцож энэхүү гэрээг байгуулав.

1.2 Энэхүү гэрээ нь 2025 оны 05 дугаар сарын 06-ны өдрөөс 2026 оны 05 дугаар сарын 05-ны өдөр хүртэл хүчин төгөлдөр үйлчилнэ.

1.3 "Хог хаягдлын тухай" хуулийн хүрээнд Хан-Уул дүүргийн нутаг дэвсгэрт орон сууц, гэр хорооллын айл өрх, ААН байгууллага болон үйлдвэрлэлийн хог хаягдлыг тээвэрлэх, түүнтэй холбогдон гарсан төлбөр тооцооны асуудлыг шийдвэрлэхэд энэхүү гэрээний зорилго оршино.

1.4 Нийслэлийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын **2013 оны 09-р сарын 26-ны өдрийн 12/45** дугаар тогтоолоор Хог тээврийн үйлчилгээний хураамжид НӨАТ /нэмэгдсэн өртгийн албан татвар/-ыг тооцоогүй болно.

1.5 Хан-Уул дүүргийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын тэргүүлэгчдийн **2024 оны 12 дугаар сарын 27-ны өдрийн дугаар 12** тоот тогтоолын дагуу гэрээний үнийн дүнг хоёр тал харилцан тохиролцон тогтоосон болно.

1.6 Хороо нь гэрээний дагуу хог хаягдал цуглуулах, тээвэрлэх хуваарийн хэрэгжилтэд хяналт тавьж Захиалагч, Гүйцэтгэгч хороондын уялдааг хангана.

Хоёр. Гүйцэтгэгчийн эрх, үүрэг

2.1 Гүйцэтгэгч нь гэрээнд заасан хуваарийн дагуу ААН байгууллага, орон сууцны бункерийн хог хаягдлыг тээвэрлэн төвлөрсөн хогийн цэгт хүргэх, ачилтын мэдээг тухай бүр хороонд мэдээлж ажиллах үүрэгтэй.

2.2 Гүйцэтгэгчийн тээвэрлэлт саатсанаас хог хаягдал хуримтлагдсан бол графикт зааснаас бусад цагаар зохион байгуулалт хийн хогийг ачуулах арга хэмжээг авна.

2.3 Гүйцэтгэгч нь гэрээний дагуу ААНБ-аас гарч буй ахуйн хогийг тогтмол цагт цуглуулах, мөн нэмэлтээр барилга барих, буулгах, засварлах тохиолдолд иргэн, аж ахуйн нэгжийн хог хаягдлыг төлбөр төлөгдсөний дараа тээвэрлэнэ.

2.4 Хог хаягдлыг тээвэрлэх аюулгүй ажиллагааны шаардлагыг хангасан, битүүмжилсэн зориулалтын тээврийн хэрэгсэлтэй байх

2.5 Хог хаягдал тээвэрлэх тээврийн хэрэгслийн жолооч, ачигч нь зохих сургалтад хамрагдаж аюулгүй ажиллагааны шаардлагыг хангаж ажиллана.

*Зураг 15. Хог хаягдал ачиж тээвэрлэх гэрээ*

4.5 Хог тээвэрлэлтийн тарифт өөрчлөлт орсон тохиолдолд талуудын төлөөлөл тохиролцон гэрээнд нэмэлт оруулж мөрдөнө. Хэрэв хатуу хог хаягдал болон барилгын засвараас гарсан чулуу, мод, шорооны хог хаягдлыг тээвэрлүүлэх тохиолдолд нэмэлт тарифыг мөрдөх бөгөөд төлбөрийг төлсний дараа гүйцэтгэгч тээвэрлэнэ.

4.6 Үйл ажиллагааны онцлогоос хамаарсан хог хаягдлын тээвэрлэлтийг өвөл, зуны батлагдсан графикийн дагуу төлбөр төлөгдсөний дараа тээвэрлэнэ.

4.7 Хог тээвэрлэлтийн төлбөрийг ААН, албан байгууллага, үйлчилгээний газрууд нь гэрээний 3.6-д заасан хугацаанд бүрэн төлж барагдуулна. Төлбөрийг хожимдуулсан тохиолдолд хоног тутам 0,5%-ийн алданги төлнө.

Тав. Хамтран хүлээх хариуцлага

5.1 Талууд энэхүү гэрээ зөрчигдөөгүй тохиолдолд дангаараа гэрээг цуцлах эрхгүй.

5.2 Талууд аливаа маргаан, үл ойлголцлыг харилцан тохиролцож шийдвэрлэх бөгөөд шаардлагатай бол холбогдох хуулийн байгууллагад хандаж шийдвэрлүүлнэ.

5.3 Нийслэл, дүүргээс зохион байгуулах их цэвэрлэгээний ажилд дайчлагдан ажиллах үед хог ачилтын хуваарь 1 өдрөөр хойш шилжих асуудал гарч болно. Үүнийг тухайн ААН, байгууллагад урьдчилан мэдэгдэх бөгөөд төлбөр төлөлтөнд ямар нэгэн өөрчлөлт орохгүй.

Зургаа. Торгуулиас чөлөөлөгдөх нөхцөл

6.1 Байгаль, цаг уурын онц ноцтой үзэгдэл тохиолдох, хүндэтгэх шалтгаанаар авто зам хаагдсаны улмаас хог ачих боломжгүй болсон.

6.2 Удирдах, дээд байгууллагын шийдвэрээр автомашиныг өөр ажилд дайчилсан тохиолдолд энэхүү гэрээний 5.2 дахь заалт хамаарахгүй.

Долоо. Бусад

7.1 Энэхүү гэрээ нь талууд гарын үсэг зурж, тамга дарснаар хүчин төгөлдөр болно.

7.2 Гэрээнд тусгагдаагүй боловч нэмж оруулах, гэрээнд өөрчлөлт хийх шаардлагатай тохиолдолд талууд харилцан тохиролцож шийдвэрлэнэ.

7.3 Тус гэрээнд дүүрэг, хорооноос тогтоосон "**хариуцах орчны 50 метр хүртэлх нийтийн эдэлбэр газар**"-ын зураглалыг хавсаргасан тохиолдолд хүчин төгөлдөр гэж үзнэ.

Найм. Нэмэлт өөрчлөлт

20... оны .... сарын ..... –ний өдөр талууд харилцан тохиролцож энэхүү гэрээнд дараах нэмэлт өөрчлөлтийг оруулав.

Ажлын .................. дахь өдөр ачилт хийх.

Ес. Гэрээний сунгалт

9.1 Гэрээний хугацаа дуусаж, талууд гэрээг цуцлах талаар албан бичгээр санал гаргаагүй бол гэрээг анх байгуулагдсан хугацаагаар сунгагдсанд тооцно.

9.1.1 Энэхүү гэрээг 20 ..... оны ..... сарын ..... өдрөөс 20 ..... оны ..... сарын ..... өдөр хүртэл талууд харилцан тохиролцож сунгалт хийсэн болно.

*Зураг 16. Хог хаягдал ачиж тээвэрлэх гэрээ*



ББР-М-01-001-009-01

БУСДААР ГҮЙЦЭТГҮҮЛСЭН АЖЛЫГ
ХҮЛЭЭЛЦСЭН АКТ

№................................ тоот гэрээт ажил

**Огноо:** 2025.08.05.

**Ажил гүйцэтгэсэн байгууллагын нэр:**..............................

**Ажлыг захиалсан:** Алба.................., Албан тушаалтан..................

**Ажлын нэр:**..............................

**Ажлын байршил:** БСММ.

Энэхүү ажлыг захиалагч болон гүйцэтгэгч талууд хоорондын тохиролцсон ажлын хүрээнд захиалагч талын комиссын гишүүд техник болон ажлын чанарыг шалгахад:

1. Ажлын гүйцэтгэл: ..............................
   80000400262000 5282.
   150,000.
2. Төлбөр тооцоо:..............................
3. Нэмэлт тодруулга:..............................
4. Ажлыг гүйцэтгэсэн хугацаа:..............................
5. Баталгаат хугацаа: Эхлэх огноо.................. Дуусах огноо..................

*Санамж: 1. Шаардлагатай тохиолдолд ажлын зургийг хавсаргана.*
*2. 2-р хэсэгт төлбөр тооцоог бүрэн болон хэсэгчлэн төлөх тухай тэмдэглэх ба гэрээнд заасан санхүүжилтийг заавал тэмдэглэнэ.*

АЖИЛ ХҮЛЭЭЛЦСЭН:

Захиалагч талыг төлөөлж:
Хянасан:
................/ /
Хүлээн авсан:
................/ /

Гүйцэтгэгч талыг төлөөлж:
Хүлээлгэн өгсөн:
................/ /
Утас:
................



**Шилжүүлгийн мэдээлэл**/Transaction Information

Журналын /Journal No: **29879251**

Гүйлгээний дугаар /Poid: **1232474115**

Системийн огноо/System Date: **2025-08-11 17:08:11**

| | | | Дүн/Amount | Ханш/Rate |
|---|---|---|---|---|
| Дт | IBAN/Дансны/Картын дугаар IBAN/Account/Card number<br>5070017051 | Нэр/Name<br>НЭРГҮЙ ГАНДОЛГОР | 150,000.00 MNT | 1.00 |
| Кт | Банкны дугаар/Branch No<br>TDBMMNUB<br>IBAN/Дансны/Картын дугаар IBAN/Account/Card Number<br>MN800004 002620005282 | Банкны нэр/Bank Name<br>ХУДАЛДАА ХӨГЖЛИЙН БАНК<br>Нэр/Name<br>ДАВААСҮРЭН ПҮРЭВДОО | 150,000.00 MNT | 1.00 |

Гүйлгээний утга/Transaction description:
ЕВ-АЧАА ТЭЭВРИЙН ҮНЭ - БСММ

*Зураг 17. Хог хаягдлын төлбөр төлсөн баримт*

# ЕС.ТУХАЙН ЖИЛИЙН ОРЧНЫ ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨРИЙН БИЕЛЭЛТ

ОХШХ-ийн хүрээнд уурхай болон бутлан ангилах үйлдвэр, ажилчдын тосгон орчмоос агаарын чанарын болон хөрсний бохирдлын дээжийг жил бүр авч шинжлүүлж байна.



ХӨРС СУДЛАЛЫН ИТГЭМЖЛЭГДСЭН ЛАБОРАТОРИ

ИНЖЕНЕР ГЕОДЕЗИ ХХК
Утас/Факс 77278899, 77288899
E-mail: soil_lab@geo-mongol.mn

Дугаар: 25/1786

**Дээж авсан огноо:** 2025 он 10 сарын 20
**Шинжилгээ хийсэн огноо:** 2025 он 10 сарын 21-22
**Дээж авсан газрын нэр:** Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг, 13-р хороо, Үнсэглэнгийн хөндий
**Координат:** -
**Дээж шинжлүүлсэн байгууллага, хувь хүн:** "Би Си Эм Эм"ХХК
**Харилцах утас:** 99152538

*Хөрсний химийн задлан шинжилгээний дүн*

| № | Лаб № | Дээжний нэр | Гүн, см | pH | Давс, % | ЦДЧ, dsm | Ялзмаг,% | $NO_3$ мг/100г | $CaCO_3$,% | Шингэгдсэн суурьууд мг-экв/100 гр | | Шим тэжээлийн элементүүд мг/100 гр | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | | Ca | Mg | $P_2O_5$ | $K_2O$ |
| 0 | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 | 10 | 11 | 12 | 13 | 14 |
| 1 | 25/8345 | Үйлдвэрийн хэсэг | - | 8.00 | 0.14 | 0.286 | 0.42 | 0.13 | 5.10 | 12.6 | 7.5 | 1.5 | 37 |
| 2 | 25/8346 | Оффис хөрс | - | 8.13 | 0.06 | 0.130 | 1.26 | 0.11 | 0.16 | 9.7 | 4.3 | 1.3 | 40 |

*Хөрсний механик бүрэлдэхүүн*

| № | Лаб № | Дээжний нэр | Гүн, см | Механик ширхэгүүд %, ширхэгийн хэмжээ, мм | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | 2-0.25 | 0.25-0.05 | 0.05-0.01 | 0.01-0.005 | 0.005-0.001 | <0.001 | <0.01 |
| 1 | 25/8345 | Үйлдвэрийн хэсэг | - | 13.6 | 46.1 | 21.2 | 6.3 | 7.4 | 5.4 | 19.0 |
| 2 | 25/8346 | Оффис хөрс | - | 32.6 | 34.5 | 19.0 | 3.8 | 2.5 | 7.6 | 13.9 |

*Хөрсний хүнд металл*

| № | Лаб № | Дээжний нэр | Гүн, см | Хүнд металл мг/кг | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | Ni /Никель | Cd /Кадми | Pb /Хар тугалга/ | Cu /Зэс/ | Zn /Цайр/ | Cr /Хром/ |
| 1 | 25/8345 | Үйлдвэрийн хэсэг | - | 8.86 | ND | 27.68 | 16.12 | 80.44 | 0.64 |
| 2 | 25/8346 | Оффис хөрс | - | 2.08 | ND | 21.78 | 12.43 | 91.07 | 3.93 |
| Хүлээх агууламж /MNS 5850:2019/ | | | | 150,0 | 3,0 | 100,0 | 100,0 | 300,0 | 150,0 |
| Хортой агууламж /MNS 5850:2019/ | | | | 1000,0 | 10,0 | 500,0 | 500,0 | 600,0 | 400,0 |
| Аюултай агууламж /MNS 5850:2019/ | | | | 1800,0 | 20,0 | 1200,0 | 1000,0 | 1000,0 | 1500,0 |
| Элементүүдийн зөвшөөрөгдөх дээд хэмжээ стандарт | | | | /MNS 5850:2019/ | | | | | |

*ND-not detect

*Жич: Энэхүү шинжилгээний хариу нь тухайн цэгийн дээжинд хамаарах ба хуулбарлан хэрэглэхийг хориглоно*

Шинжилгээ хийсэн арга стандарт.
(MNS 3310:1991, MNS ISO 10390:2001, MNS [illegible] ISO [illegible]988:2022, MNS ISO 11466:2007)

Лабораторийн эрхлэгч [illegible] Цагаандархи /MS.c/-г.

Задлан шинжээч [illegible] Ганцэцэг

*Зураг 18. Хөрсний шинжилгээний хариу*

**ХӨРС СУДЛАЛЫН ИТГЭМЖЛЭГДСЭН ЛАБОРАТОРИ**

**ИНЖЕНЕР ГЕОДЕЗИ ХХК**
Утас/Факс 77278899, 77288899
E-mail: soil_lab@geo-mongol.mn

**Дугаар: 25/1787**

**Дээж авсан огноо:** 2025 он 10 сарын 20
**Шинжилгээ хийсэн огноо:** 2025 он 10 сарын 21-22
**Дээж авсан газрын нэр:** Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг, 13-р хороо, Үнсэгэнгийн хөндий
**Координат:** -
**Дээж шинжлүүлсэн байгууллага, хувь хүн:** "Би Си Эм Эм"ХХК
**Харилцах утас:** 99152538
**Уст цэгийн төрөл ба дугаар:** Цэвэр ус
**Лаб № 25/8347**

Усны химийн задлан шинжилгээний дүн

| Анион | мг/л | мг/экв | %, мг-экв/л | Катион | мг/л | мг/экв | %, мг-экв/л |
|---|---|---|---|---|---|---|---|
| $Cl^-$ | 35.45 | 1.00 | 14.79 | $Na^++K^+$ | 23.27 | 1.01 | 14.99 |
| $SO_4^{2-}$ | 84.37 | 1.76 | 26.02 | $NH_4^+$ | 0.40 | 0.02 | 0.33 |
| $NO_3^-$ | 24.42 | 0.39 | 5.84 | $Ca^{2+}$ | 88.18 | 4.40 | 65.19 |
| $NO_2^-$ | 0.03 | 0.00 | 0.01 | $Mg^{2+}$ | 15.81 | 1.30 | 19.26 |
| $CO_3^{2-}$ | 0.00 | 0.00 | 0.00 | $Fe^{2+}$ | 0.30 | 0.02 | 0.24 |
| $HCO_3^-$ | 219.67 | 3.60 | 53.33 | $Fe^{3+}$ | 0.00 | 0.00 | 0.00 |
| Дүн | 363.95 | 6.75 | 100.00 | Дүн | 127.95 | 6.75 | 100.00 |

Анион катионуудын нийлбэр: 491.90 мг/л
$HCO_3^-$ ийн хагасыг хассан анион катионуудын нийлбэр: 382.0 мг/л
Хуурай үлдэгдэл: 490.0 мг/л
Ерөнхий хатуулаг: 5.70 мг-экв/л
pH: 7.79
Исэлдэх чанар: 0.64 мг/л

Усны физик шинж. чанар

Шүүгдэсний өнгө: Өнгөгүй
Үнэр: Үгүй
Амт: -
Булингар: Тунгалаг
Тунадас: Үгүй

**Усны давсны химийн найрлагын томьёо** $M\,(490.0\ мг/л) = \frac{HCO-53.33\ SO-26.02}{Ca-65.19}$

Тайлбар

Химийн бүрэлдэхүүнээрээ гидрокарбонатын ангийн, кальцийн бүлгийн, 2-р төрлийн , чанарын хувьд цэнгэг буюу дунд зэргийн эрдэсжилттэй, хатуу ус байна.

Шинжилгээ хийсэн арга стандарт:
(MNS 1097:1970, MNS 6271:2011, MNS ISO 10523:2001, MNS ISO 9297:2005, MNS ISO 6059:2005)

Лабораторийн эрхлэгч: Д. Цагаандархи /MS.c/
Задлан шинжээч: Алтанцэцэг /MS.c/

ИТГЭМЖЛЭГДСЭН ЛАБОРАТОРИ

*Зураг 19. Усны шинжилгээний хариу*

ЦАГ УУР, ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭНИЙ ГАЗАР
БАЙГАЛЬ ОРЧИН, ХЭМЖИЛ ЗҮЙН ТӨВ ЛАБОРАТОРИ

17043, Үйлдвэр 2-4, Чингисийн өргөн чөлөө гудамж,
Хан-Уул дүүрэг, 20-р хороо, Утас: 11-341818
E-mail: bohztl@gmail.com

БАЙГАЛЬ
ОРЧИН ХЭМЖИЛЗҮЙН ТӨВ ЛАБОРАТОРИ

СОРИЛТЫН ДҮН

Дугаар он/№ : 2023/А-318
Сорьц ирүүлсэн газрын нэр, хаяг, утас : "Би Си Эм Эм"ХХК
Сорьцын авсан хүний нэр, албан тушаал : Б.Батхишиг агаарын хэсэг
Сорьцын тоо, төрөл : 2 агаар, 2 дуу чимээ
Сорьц авсан огноо : 2023.10.22
Сорьцын тодорхойлолт : Улаанбаатар хот ХУД 12-р хороо дайрганы үйлдвэр
Шинжилгээний аргын стандарт : MNS 17-2-5-12:2021, MNS 17-2-5-11:2021 MNS 5002:2000, САЗ А07-2016
Шинжилсэн огноо : 2023.10.25
Хуудасны тоо : 1/1
Үр дүн :

| № | Сорьц авсан цэг | Сорьц авсан өдөр | Сорьц авсан цаг | Хүхэрлэг хий | Азотын давхар исэл | Нийт тоос /TSP/ | Дуу чимээ |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | мг/м³ | | | ДБА |
| 1 | Үйлдвэрийн орчмоос | X/22 | 08:20 | 0.014 | 0.020 | 0.120 | 65 |
| 2 | Ажилчдын кемп | X/22 | 09:05 | 0.012 | 0.018 | 0.078 | 38 |
| **Агаарын чанарын техникийн ерөнхий шаардлага MNS 4585:2016, Хүлцэх агууламж (20 минутын хэмжилт)** | | | | **0.450** | **0.200** | **0.500** | **60** |

Шинжилгээ гүйцэтгэсэн инженер: Э.Оюунтуяа

Хянаж баталгаажуулсан инженер: /Чанарын менежер/ Б.Алтантуяа

ИТГЭМЖЛЭГДСЭН ЛАБОРАТОРИ

Хуулбарлан хэрэглэхийг хориглоно.
Сорилтын дүн нь зөвхөн шинжилсэн сорьцонд хүчинтэй

*Зураг 20. Агаарын чанар, дуу чимээний шинжилгээний хариу*

# АРАВ. УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

Удирдлага зохион байгуулалтын менежментийн төлөвлөгөөний дагуу 2025 оны уулын ажлын төлөвлөгөө, БОМТ-г боловсруулсан батлуулсан ба үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ажилласан болно. Түүнчлэн ажилчдыг ХХАА-ны хувцас хэрэгслээр бүрэн хангаж ажилласан.




*Зураг 21. Ажилчдын хувцас*



ШИЛЖҮҮЛЭГЧИЙН ДАНСНЫ МЭДЭЭЛЭЛ

| | |
|---|---|
| Банкны нэр: | ХасБанк |
| Данс: | 5001699529 |
| Нэр: | - |
| Дүн: | 3,456,200.00 |
| Валют: | MNT |

ХҮЛЭЭН АВАГЧИЙН ДАНСНЫ МЭДЭЭЛЭЛ

| | |
|---|---|
| Банкны нэр: | ХААН Банк |
| Данс: | 5121 037 685 |
| Нэр: | ХҮҮГИЙН ГУТАЛ ХХК |
| Дүн: | 3,456,200.00 |
| Валют: | MNT |

ГҮЙЛГЭЭНИЙ МЭДЭЭЛЭЛ

Гүйлгээний дугаар: 000171411161
Гүйлгээний утга: Гуталны үнэ - бат бэх /5180651
Гүйлгээний шимтгэл: 200.00MNT

Гүйлгээний хүсэлт илгээсэн: batbehremicon2
Гүйлгээ баталсан: batbehremicon1

Гүйлгээ хийсэн огноо: 2025-06-13

*Зураг 22. Хөдөлмөр хамгааллын хувцас худалдан авсан баримт*



Байгууллагын нэр: Ди Эм Эйд Ай Жи ХХК
Хаяг:
Утас: Факс: 88114518
Э_шуудан
Банкны нэр ХАС
Банкны дансны дугаар 5000879088
Регистрийн №:

Байгууллагын нэр: БАТ БЭУ РЕМИКОН ХХК
Хаяг:
Гэрээний №
Нэхэмжилсэн огноо 2025.6.10
Төлбөр хийх хугацаа

| № | Гүйлгээний утга | Тоо хэмжээ | Нэгжийн үнэ | Нийт үнэ |
|---|---|---|---|---|
| | Ажлын 3хос хувцас | 10ш 3хос | 150'000 | 1500'000 |
| | 65% полиэстр 35% даавуу | | | |
| | Ажлын 3хос хувцас | 45ш 3хос | 136'363 | 6'136'363 |
| | 80% полиэстр 20% даавуу | | | |
| | Жакет | 1ш | 59'090 | 59'090 |
| | Хантааз | 1ш | 39'090 | 39'090 |
| | Өмд | 3ш | 38'181 | 114'545 |
| | | | | |
| | Урьдчилгаа 40% | | → | 3'139'636 |
| | | | Дүн | 3'139'636 |
| | | | НӨАТ | 313963 |
| | | | | |
| | | | Нийт дүн | 3453600 |

Мөнгөний дүн Гурван сая дөрвөн зуун тавин гурван мянга зургаан зуун төгрөг (үсгээр) болно.

Ди Эм Эйд Ай Жи ХХК (Тамга)

Дарга ........ / Б. Дашмөнгөч
Хүлээн авсан ........ / ........ /
Нягтлан бодогч ........ / ........ /

Тэмдэг Хүлээн авсан: ........ / ........ /
Хүлээлгэн өгсөн: ........ / ........ /

*Зураг 23. Хөдөлмөр хамгааллын хувцас худалдан авсан баримт*

# АРВАН НЭГ. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТИЙГ НӨЛӨӨЛӨЛД ӨРТӨГЧ ОРШИН СУУГЧИД, ОРОЛЦОГЧ ТАЛУУДАД ТАЙЛАГНАХ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тайланг боловсруулан БОАЖЯ-ны цахим системд илгээсэн болно.

*Хүснэгт 6. 2025 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хүрээнд хийж гүйцэтгэсэн ажлын зардал*

| № | Бүрэлдэхүүн хэсгүүд | Хэмжих нэгж | Тоо хэмжээ | Нэгжийн зардал мян.төг | Нийт зардал мян.төг | Тайлбар, үндэслэл |
|---|---|---|---|---|---|---|
| 1 | Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт | ш | 10 | 1062.5 | 1062.5 | "Тэрбум мод" үндэсний хөдөлгөөний хүрээнд уурхайн талбайд 50 ш мод тарьсан, уурхайн талбайд тэмдэг тэмдэглэгээ байрлуулсан. |
| 2 | Нөхөн сэргээлтийн төлөвлөгөөний биелэлт | - | - | - | - | 2025 оны УАТ-нд техникийн болон биологийн нөхөн сэргээлтийн ажил төлөвлөөгүй болно. |
| 3 | Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт | га | 1 | 2000.0 | 2000.0 | Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний хүрээнд НБОГ-тай хамтран ажилласан. |
| 4 | Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт | - | - | - | - | Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээ төлөвлөх шаардлагагүй |
| 5 | Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт | - | - | - | - | Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээ төлөвлөх шаардлагагүй. |
| 6 | Химийн бодисын эрсдлийн менежментийн төлөвлөгөөний биелэлт | ш | 4 | - | 82 500.0 /Үйл ажиллагааны зардал/ | Тэсрэх материалыг мэргэжлийн гэрээт байгууллагаар гүйцэтгүүлж, сав баглаа боодлыг хүлээлгэн өгсөн |
| 7 | Хог, хаягдлын менежментийн төлөвлөгөөний биелэлт | ш | 2 | 150.0 | 150.0 | Дүүргийн тохижилт үйлчилгээний төвтэй гэрээ байгуулан ажилласан, хог хаягдлын ангилан ялгах цэгийг тохижуулсан. |
| 8 | Удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөөний биелэлтийн тайлан | ш | 1 | 3456.2 | 3456.2 | Ажиллагсдыг хөдөлмөр хамгааллын хувцас хэрэгслээр бүрэн хангаж ажилласан. Үйлдвэрийн талбайд галын булан байгуулсан. |
| 9 | Олон нийтэд тайлагнах хуваарь, төлөвлөгөөний биелэлт | - | - | - | - | Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тайланг боловсруулж, БОУАӨЯ-ны цахим системд илгээсэн. |
| 10 | Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн биелэлт | ш | Хөрс, усны дээж, агаар, дуу чимээ | | 600.0 | Хөрс, усны дээж авч лабораторид шинжлүүлсэн. |
| | **Дүн** | | | | **7268.7** | |

## ДҮГНЭЛТ

Манай компани нь 2025 онд байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хүрээнд дараах ажлуудыг хийж гүйцэтгэлээ. Үүнд:

- ✓ Тоосжилт ихтэй үед зам усалгааг тогтмол хийж байсан.
- ✓ Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний хүрээнд НБОГ-тай хамтран ажилласан. Уг ажлын зардалд 2.0 сая төгрөг зарцуулсан болно.
- ✓ Хог хаягдлын гэрээ байгуулж, гэрээний дагуу тээвэрлүүлж байсан. Түүнчлэн хог хаягдлыг түр хадгалах цэг, аюултай хог хаягдлын түр цэгийг байгуулж ашиглалтад оруулсан.
- ✓ Ажилчдыг хөдөлмөр хамгааллын хувцас хэрэгслээр бүрэн хангаж ажилласан.
- ✓ Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн хүрээнд агаарын чанар, дуу чимээний хэмжилт хийлгэж, хөрсний шинжилгээ авч лабораторид шинжлүүлсэн.
- ✓ Ус ашиглуулах дүгнэлт гаргуулж, ус ашиглах гэрээ, ус ашиглах гэрчилгээ зэргийг холбогдох газруудаас гаргуулсан.
- ✓ Өрөмдлөг тэсэлгээний ажлыг мэргэжлийн байгууллагаар гүйцэтгүүлсэн бөгөөд тэсрэх бодисын сав баглаа боодлыг гэрээт байгууллагад буцаан өгч аюул осолгүй ажилласан.

2025 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөгөөр хийгдэх ёстой ажлуудыг цаг тухайд нь 100 хувь хийж гүйцэтгэсэн болно.